

Эхсийн ийлдсэнд хийсэн вирус судлалын шинжилгээний дүн

Сайнчимэг Б.¹, Дуламсүрэн О.², Ичинхорлоо Б.¹, Алтантуяа Л.¹, Оюунбилэг Ж.¹,

¹Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн

²Хавдар Судлалын Үндэсний Төв

sainchimeg@yahoo.com

Үндэслэл

Хепатитын В, С вирусийн халдварын тархалт дэлхийн олон орны эрүүл мэндийн асуудал байсаар байна. Парентераль зам, бохир гар-амаар зонхилон халдварладаг эдгээр вирус нь мэсзасал, эмчилгээ, гоо сайхны зорилгоор хийж буй арьс цоолох бүх үйлдлүүд, цус сэлбэх, цус цусан бүтээгдэхүүний эмчилгээ хийх болон бэлгийн замаар халдварладаг байна. Дэлхий нийтэд сүүлийн жилүүдэд шинээр гарч байгаа болон дахин сэргэж буй халдварт өвчнүүдийн халдварыг эмчлэх, сэргийлэх, эрхтэн шилжүүлэн суулгуулсан, гемодиализ хийлгэж байгаа өвчтөнүүд халдвар авахаас урьдчилан сэргийлэх зорилгоор өвөрмөц иммуноглобулиныг өргөнөөр хэрэглэх болж хэрэглээ нь ихсэж байна. Биотехнологийн үйлдвэр нь донорын цус, эхсийн ийлдсийг ашиглан хүний хэвийн иммуноглобулин, уургийн бэлдмэл, гистаглобулин зэрэг биобэлдмэлүүдийг үйлдвэрлэдэг. Мөн томуугийн эсрэг иммуноглобулиныг донорын цуснаас үйлдвэрлэж, клиник туршилтыг амжилттай хийсэн бөгөөд В хепатитын эсрэг өвөрмөц иммуноглобулин, С хепатитын эсрэг өвөрмөц иммуноглобулин үйлдвэрлэх туршилта судалгааны ажлууд хийгдэж технологи боловсруулагдсан билээ. Одоо А хепатитын эсрэг өвөрмөц иммуноглобулин үйлдвэрлэх туршилта хийгдэж байна. Бид бүтээгдэхүүний биоаюулгүй байдлыг хангахын тулд түүхий эд, үйлдвэрлэлийн шат дамжлагын болон бэлэн бүтээгдэхүүнд хепатит В, С, ХДХВ болон бичил амь судлал, биологи, биохимийн бусад олон үзүүлэлтүүдийг шинжилж, цус цусан бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангаж ажилладаг болно.

Зорилго

Бүтээгдэхүүн үйлдвэрлэхтүүхийэдэд вирус судлалын шинжилгээ хийж, цус цусан бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах

Арга зүй

Энэхүү судалгаанд бид Улаанбаатар хотын Нийслэлийн Өргөө, Нийслэлийн хүрээ, Нийслэлийн Амгалан зэрэг амаржих эмнэлгүүд, ЭХЭМҮТ-ийн амаржих газрын нэгдүгээр тасгаар үйлчлүүлсэн 8825 эрүүл эхийн эхсийн цусыг цуглуулан хепатит В, С, А вирусийн маркер, ХДХВ-ийн эсрэгбие илрүүлэх шинжилгээг Фермент холбоот урвал, хепатит В, С вирусийн нуклейн хүчлийг полимеразын гинжин урвалын аргаар Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн Биобэлдмэлийн үйлдвэрийн чанарын хяналтын лаборатори, Биотехнологи, молекул биологийн секторын вирус судлалын лабораториудад шинжлэв.

Үр дүн

Биобэлдмэлийн бүтээгдэхүүний гол түүхий эд болох эхсийн цусны 22.49%-д нь хепатитын вирусийн маркер эерэг тодорхойлогдов. 2010-2012 онд 8825 эхэсийн ийлдсэнд хепатитын В вирусийн эсрэгтөрөгчийг шинжлэхэд 1091 буюу 12.36% нь

(+) эерэг, HBsAg(-) сөрөг 7793 ийлдсэнд anti-HCV шинжлэхэд 897 буюу 11.5% нь (+) эерэг байлаа. Эдгээр ийлдсээс 508 ийлдсэнд хепатитын В,С вирусийн маркерийг хоёуланг нь шинжлэхэд 3 ийлдсэнд HBsAg, anti-HCV хоёулаа илэрсэн. Шинжилгээг баталгаажуулан анти-HCV(+) эерэг тодорхойлогдсон 89 ийлдэс сонгон HCV(RHX)-ийг ПГУ-ын аргаар шинжлэхэд 24 /26,96%/ нь HCV RHX(+) эерэг тодорхойлогдлоо.

Хепатитын маркер сөрөг ийлдсүүдээс санамсаргүй сонголтоор 75 ийлдэс сонгон хепатитын А вирусийн эсрэгбие (anti-HAV-IgG) илрүүлэх шинжилгээ хийхэд 67 буюу 89.3% нь anti-HAV- IgG(+) эерэг байгаа нь П.Нямдаваа нарын судлаачдын 1982,1984 онуудад хийгдсэн судалгааны дүнтэй нийцэж байна.

Хепатитын В, С вирусийн маркер илрээгүй 6835 ийлдсийг багцлан анти-HIV- ийн маркер тодорхойлоход эсрэгбие илрээгүй болно.

Дүгнэлт

1. Нийт цуглуулсан түүхий эдийн 75 орчим хувь нь үйлдвэрлэлийн шаардлага хангаж байсан бөгөөд эхсийн ийлдсийн 22,5%-нь хепатитын маркер эерэг, 2,5%-нь гемолиз болсон, бохирдсон зэрэг шалтгаанаар хасагдсан байна.

2. Амаржсан эхчүүдийн дунд хепатитийн вирус тээгчийн эзлэх хувь өндөр байв.

3. Төрөх эмнэлгүүдийн нэгдүгээр тасагт амаржих эхчүүдийг хепатитын вирусийн маркер илрүүлэх шинжилгээнд бүрэн хамруулж, зөвхөн эрүүл эхчүүдийг хүлээн байх нь эмнэлгийн ажилчдыг халдвараас сэргийлэх, цаашилбал эхсийн цус, ийлдэсээр хийх бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой.

Түлхүүр үг: Эхсийн ийлдэс, хепатитын маркер, ФХУ, ПГУ